



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 01

Сүхбаатар сум

Дотоод аудитын хорооны анхдугаар хуралдаан

Дотоод аудитын хорооны хурал 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09:00 цагаас Засаг даргын хурлын өрөөнд эхэлж 10:00 цагт дуусав. Хурлын ирц 85.7 хувьтай байв.

Хуралд:

Дарга:	Н.Лхагвадорж
Нарийн бичгийн дага:	Т.Мөнхзул
Гишүүд:	Ө.Сувдаа
	Т.Одсүрэн
	Б.Янжинхлам
	А.Дашбат
	А.Гэрэлмаа

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны товч тайлан
2. Батлагдсан орон тоо хүний нөөцийн бодлого төлөвлөлт
3. 2023 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн
4. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө,
5. Дотоод аудитын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, хяналт шалгалтад хамруулах байгууллагын эрсдэлийн үнэлгээнд суурилсан хуваарийг батлах тухай.

СОНССОН НЬ: Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Т.Одсүрэн хэлэлцэх асуудлын хүрээнд мэдээллийн танилцуулгыг хийв.

Ө.Сувдаа: Албаны даргын танилцуулсан мэдээллийг сонсоод тодруулж асуух хэд хэдэн зүйл байна. Үүнд:

1. Батлагдсан төсөв санхүүжилтийг бүрэн олгохгүй байгаа шалтгаан.
2. Хүний нөөцийн хангалт, бүтэц орон тооны өөрчлөлтийг хийх хэрэгцээ шаардлага үүссэн нөхцөл байдлыг тодруулж асуумаар байна.

Т.Одсүрэн: Мэдээлэлд дурдагдсанаар өнгөрсөн жилийн батлагдсан төсөв 255.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 170.5 сая төгрөгийг зарцуулж, 66.8 хувьтай буюу 84.5 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан нь батлагдсан орон тоогоор ажиллах хүний нөөцийн дутагдал энэ нь хяналт шалгалтын байгууллагын албан хаагчид тавигдах тусгай шаардлага нь өндөр боловч санхүү бүртгэлийн ажил хийж байгаа төрийн албан хаагчдын цалингийн зэрэглэлтэй ижил түвшинд байгаагаас шалтгаалж байна.

Мөн өнгөрсөн онд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг СТСХ-ийн ерөнхий нягтлан бодогч гүйцэтгэлээр санхүүжилт олгох нэрээр төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн олгоогүй нь тус албаны санхүүгийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлсөн зэрэг шалтгаанууд байна. Энэ нь тухайн албан хаагчийн хувийн харьцаа хандлагаас шалтгаалж байгаа нь илэрхий байдаг. Жишээ дурдахад ТЕЗ-ийн зөвшөөрлөөс зардлын эдийн засгийн ангилал хооронд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төсвийн зохицуулалт хийх зөвшөөрлийг авч албанд шаардлагатай техник хэрэгслийг авах гэсэн боловч санхүүжилтийн эрхийг нээж өгөхгүй байсаар төсвийн жилийн хугацааг дуусгасан.

Манай албанд хяналт шалгалтаар явахад ашиглах зөөврийн компьютер, дуу хураагуур, онлайн хурал, зөвлөгөөн хийх болон цахим сургалт хамрагдах, явуулах тоног төхөөрөмж байхгүй зэрэг асуудлыг батлагдсан төсөвтөө багтаан шийдэх гэсэн боловч санхүүжилтийг олгоогүй асуудлууд гаргасан. Үүнийгээ болохоор аймагт танай төсвийг өгөх мөнгө байхгүй аль эсвэл, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах зардлыг санхүүжүүлэхгүй, албан хаагчид чинь юу хийсэн гэж үр дүнгийн урамшуулал өгөх гээд байгаа юм гэх байдлаар аль болох санхүүжилт өгөхөөс татгалзсан гуйлгах байдлаар хандаж байгаа нь албаны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Дараагийн асуултад хариулт өгөхөд жилээс жилд байгууллагуудын төсвийн зардлын хэмжээ өсөхийн зэрэгцээ төрөөс баримталж байгаа төвлөрлийг сааруулах орон нутагт эрх шилжүүлэх бодлогын хүрээнд хууль тогтоомжууд ихээр шинэчлэгдэн хяналт, шалгалт хийх цар хүрээн нэмэгдэж байгаа нь ачааллыг нэмэгдүүлэх, бүтэц орон тооны оновчтой зохион байгуулалтгүй байгаагаас сул орон тоог нөхөхөд хууль эрх зүйн хувьд уялдаагүйгээс шалгуур хангахгүй ажил чиг үүргийг тодорхойлсон албан тушаалын тодорхойлолт нь батлагдсан орон тооны албан тушаалтайгаа тохирохгүй зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байгаа нь хяналт шалгалтыг үр дүнтэй явуулахад бэрхшээл үүсгээд байгаа асуудлууд бий.

Иймд бүтэц орон тоо, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, цалингийн зэрэглэлд бүтэц орон тооны өөрчлөлтөөр дамжуулан цалингийн зэрэглэлийг ахиулах, хүний нөөцийг хангах боломж нөхцөлийг бүрдүүлж хяналт шалгалтын чанар, үр нөлөөх дээшлүүлэх боломжтой болно.

А.Дашбат: Хамгийн гол нь аудитын хэрэгцээ шаардлагыг сайн тодорхойлж Засаг даргад танилцуулж аудит хийхэд ачаалал ямар байгаагаа танилцуул цаашид ямар арга хэмжээг авбал ачаалал буурах, хяналт шалгалтыг хийснээр хүрэх үр дүнгийн талаар мэдээлэхгүй бол танай байгууллагын хувьд эхлэхдээ буруу эхэлсэн юм шиг

эсвэл тийм ойлгомжгүй, яг хаана хүрэх гээд байгаа нь тодорхой бус ийм л байгууллага, дээрээс нь улсын байцаагчийн эрхтэй юм шиг гэтэл эрхтэй байцаагч байхгүй, Хяналт шалгалт хийх гэж байгаа хүмүүсээ чадавхжуулах асуудал нэлээн дутмаг, сургалтад хамруулах шаардлагатай санагдаад байдаг.

Ө.Сувдаа: Тус албанаас эрсдэлийн үнэлгээнд Хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагуудын талаар мэргэжлийн хүмүүс нь хийсэн асуудал дээр санал алга, харин албаны хүний нөөцийн бодлого төлөвлөлт дээр бүтэц, орон тооны санал хувилбарын хувьд хууль тогтоомж, үйл ажиллагааны онцлогтой нь уялдуулан дотоод аудитыг бэхжүүлэхэд өөрчлөх, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулахыг зарчмын хувьд дэмжиж байна.

Тус албаны бүтэц орон тоог дахин хэлэлцэж шинэчлэн тогтоох болон 2023 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг баталгаажуулах гэсэн 2 асуудлыг дараагийн хурлаар нухацтай хэлэлцэх саналыг гаргаж байна. Учир нь ТЕЗ-ийн харьяа агентлагуудаас сайд нартай байгуулах гэрээнд тусгах ажлыг саналыг нэгтгэж байгаатай уялдуулан өнөөдрийн хуралдаанаар хараахан шийдвэрлэх цаг хугацаа хомс байгааг гишүүд харгалзан үзнэ үү.

Бусад гишүүд: Цаг үеийн ажил давхацсан тул хойшлуулах саналыг дэмжив.

А.Дашбат: Тус алба нь 2014 байгуулагдсанаас хойш өнөөдрийг хүртэл ерөнхийдөө санхүү дээр хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн харагдаад байдаг. Гэтэл дүрэмдээ ч тэр журмаараа гүйцэтгэл, нийцлийн аудит хийх боломжтой юм биш үү. Тэгэхээр ийм шаардлага байгаад байна. Энэ албаны үйл ажиллагааг хяналт шалгалтын чиглэлээр цэгцэд нь оруулъя гэвэл санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн чиглэлээр мэргэшсэн байдлаар орон тоо бүтцийг бий болгоод мэргэшүүлэх шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн аудит нь үр дүнд чиглэсэн, нийцлийн аудит нь хууль эрх зүйг гэрээний хэрэгжилтэд чиглэсэн аудит учраас хороо энэ чиглэлээр нь ТЕЗ-ийн түвшинд захиалгат аудитыг хийж болохоор дүрэм дээр байна.

Санхүүгийн аудитыг бол тэр чигээрээ эрсдэл нь тодорхой байна. Тэр нь юу гэхээр Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитаар ТЕЗ-ийн харьяа байгууллагууд дээр гарч ирж байгаа зөрчлийн дүгнэлтийг үндэслэх боломжтой байна. Энэ эрсдэл дээр нь санхүүгээр мэргэшсэн мэргэжилтнүүд нь жилийн хугацаандаа дараагийн аудит хүртэл ажиллаад тэр гарсан эрсдэлүүдийг бууруулсан байх нь санхүүгийн аудитын мэргэжилтнүүд хүрэх үр дүн байна.

Гүйцэтгэлийн аудитын түвшинд харин арай өөр ойлголт явагдана байгууллагын засаглалаас хамаарч үйл ажиллагааны үр дүн, үр ашигтай байдалд үнэлэлт дүгнэлт өгөөд цаашид сайжруулах шаардлагатай зүйл дээр нь зөвлөн туслах чиглэлээр дотоод аудит үүргээ гүйцэтгээд явах нь зүйтэй байна.

ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны үр ашигтай байдлыг сайжруулах чиглэлээр дотоод аудитын албанаас үр дүнтэй аудит хийгдэхгүй санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээд байгаа асуудлыг цаашдаа халах нь зүйтэй. Учир нь санхүүгийн

хяналт нь илэрсэн зөрчилд арга хэмжээ аваад өнгөрч байгаа нь дотоод аудитын зорилгодоо хүрэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- ✓ Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Дотоод аудитын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, хяналт шалгалтад хамруулах байгууллагын эрсдэлийн үнэлгээнд суурилсан хуваарийг тогтоолоор баталгаажуулах.
- ✓ Тус албаны бүтэц орон тоог шинэчлэх асуудлыг дараагийн хурлаар дахин хэлэлцэх
- ✓ 2023 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг дараагийн хурлаар дахин хэлэлцэж баталгаажуулахаар тус тус шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ДАРГА



Н.ЛХАГВАДОРЖ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР  Т.МӨНХЗУЛ

ХУРЛЫН ЦАГ ХҮСЭХ ТУХАЙ

Хэнд: Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж танаа

Хаанаас: Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга, Т.Одсүрэн

Утга: Дотоод аудитын хорооны хурлын тов хүсэх тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны үр дүн, 2024 онд гүйцэтгэх дотоод аудитын хяналт шалгалтын төлөвлөгөө танилцуулгыг Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Дотоод аудитын хорооны дүрмийн танилцуулга
2. Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны товч тайлан
3. Батлагдсан орон тоо хүний нөөцийн бодлого төлөвлөлт
4. 2023 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн
5. Дотоод аудитын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, хяналт шалгалтад хамруулах байгууллагын эрсдэлийн үнэлгээнд суурилсан хуваарь

Сангийн сайдын 2019 оны 29 тоот тушаалаар батлагдсан Сангийн яамны "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 5.2.1-д "Хорооны нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, гишүүдэд хурлын товлогдсон өдрөөс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ" гэж заасан.

Иймд Дотоод аудитын хорооны хурлын товыг тогтоож өгнө үү.

Хянасан:

АЛБАНЫ ДАРГА

Т.ОДСҮРЭН

Боловсруулсан:

ДОТООД АУДИТОР

Мөнхзүл Т.МӨНХЗУЛ

БАТЛАВ
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА
Н.ЛХАГВАДОРЖ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНААС ДОТООД АУДИТЫН
ХОРООГООР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны дүгээр сарын ...-ны өдөр

д/д	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Танилцуулах албан тушаалтан
1	Дотоод аудитын хорооны дүрмийн танилцуулга	10-15 минут	Албаны дарга
2	Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны товч тайлан	5 минут	Албаны дарга
3	Батлагдсан орон тоо хүний нөөцийн бодлого төлөвлөлт	10 минут	Албаны дарга
4	Дотоод 2023 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн	10-15 минут	Албаны дарга
5	Дотоод аудитын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, хяналт шалгалтад хамруулах байгууллагын эрсдэлийн үнэлгээнд суурилсан хуваарь	15-20 минут	Албаны дарга

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:








ДОТООД АУДИТОР *Monchzul* Т.МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

АЛБАНЫ ДАРГА *[Signature]* Т.ОДСҮРЭН

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ГИШҮҮДИЙН
ИРЦИЙН БҮРТГЭЛ

2024 оны 01 дүгээр сарын 24 –ний өдөр 09 цагт

д/д	Хорооны гишүүдийн нэрс	Албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Н.Лхагвадорж	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	3/24	
2	Т.Одсүрэн	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга	3/24	
3	Ө.Сувдаа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	24/1/2024	
4	П.Эрдэнэсайхан	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга	—	
5	Б.Янжинлхам	Хууль эрх, зүйн хэлтсийн дарга	2/24	
6	А.Гэрэлмаа	Төрийн бус байгууллагын төлөөлөл /Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын менежер/	3/24	
7	А.Дашбат	Иргэний төлөөлөл /Монголын Мэргэшсэн нягтлан бодогч/	3/24	

БҮРТГЭЛ ХӨТӨЛСӨН.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Т.МӨНХЗУЛ